НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 26 өдөр Дугаар 15/06 Улаанбаатар хот

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн худалдаа үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих, хүн амыг соёлтой, хүртээмжтэй, чанартай худалдаа, үйлчилгээгээр хангах зорилгоор "Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ – 2020" дэд хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Батболд/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА С.АМАРСАЙХАН

1111100021

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны
өдрийн 15/06 дугаар тогтоолын хавсралт

"ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ-2020" НИЙСЛЭЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, "Үндэсний үйлдвэрлэл" хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх заалтууд тусгагдсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийслэлд нэн шаардлагатай Ноу-Хау, дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг франчайз хэлбэрээр нутагшуулахыг дэмжих, нийслэлийн хүн амын хүнсний эрүүл, аюулгүй бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулж, бодлогын хэрэгжилтийг хангах, "Улаанбаатар брэнд" /UB brand/ бий болгон жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, "Худалдаа, үйлчилгээ-2020" нийслэлийн дэд хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн болно.

Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбар нь хүн амыг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, хоол хүнсээр тогтвортой хангахад чухал үүрэгтэй, дотоодын үйлдвэрлэлийн өсөлтийг хангадаг, эдийн засагт онцгой үүрэгтэй, аялал жуулчлалын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг салбар юм.

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д бүтээмжтэй, зохистой ажлын байр бий болгох, аж ахуй эрхлэх, бүтээлч байдлыг хөхүүлэн дэмжиж, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих, Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангах, өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжин урамшуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, чанарыг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт хүн амыг шим тэжээллэг, аюулгүй хүнсээр жигд хангах, нийтийн хоол үйлдвэрлэлийн хоолны чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах, нийтийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох, нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээний чанар, шим тэжээлийн агууламжийг дээшлүүлэх, нэгдсэн жор, технологийг боловсруулж мөрдүүлэх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, хүн амын хоол хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн бол Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан "Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратеги"-д нийтийн хоолны чанар, шимт тэжээлийн агууламжийг дээшлүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, хоол, хүнсний чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын байгууллагын тогтолцоог сайжруулах, мэргэжлийн боловсон хүчнийг салбарын хөгжил, стратегитай уялдуулж бэлтгэх, мэргэшүүлэх, хүнсний аюулгүй

байдлын сургалтын давтамж, хүртээмж, чанар, үр дүнг сайжруулахаар заасан байна.

Монгол Улсын нийт хүн амын 45.6%, бизнес эрхлэгчдийн 70 гаруй хувь нь төвлөрдөг нийслэл хотын худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нэн чухал бөгөөд үүнийг дараах тоон үзүүлэлтүүдээс харж болно.

Статистикийн мэдээллээр 2017 оны жилийн эцэст улсын хэмжээнд бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт 77,1 мянган аж ахуйн нэгж байгаа бөгөөд 29.9 мянга буюу (38.7%) нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт 3486 цэг хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Уг хөтөлбөрийг үндэслэлтэй боловсруулах үүднээс мэргэжлийн эрдэмтэн судлаачдын багтай хамтран хийсэн нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын өнөөгийн нөхцөл байдлын судалгааны үр дүнгээс үзэхэд салбарын эрх зүйн орчин хангалтгүй, мөрдөж буй стандартууд өнөөгийн нөхцөл шаардлагад нийцэхгүй болсон, ажиллах хүчний мэдлэг, ур чадвар дутмаг, ажиллагсдыг мэргэшүүлэх, давтан сургах нөхцөл хангагдаагүй, бараа татан авалт, тээвэрлэлтийн нэгдсэн системгүйгээс үр ашигт байдал хангалтгүйн дээр авто замын түгжрэл, агаарын бохирдол гэх мэт эдийн засаг-нийгмийн олон сөрөг үр дагавар үүсгэдэг, орчин үеийн технологийн дэвшил, инновац, шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбар нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед нарийн төлөвлөлт, хяналт, зохицуулалтын дор мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, үйлчилгээний чанар, соёл, хүртээмжтэй байдлыг хангахад онцгой анхаарч эдийн засгийн томоохон салбарууд болон хөгжсөн билээ. Гэвч зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс тэрхүү тогтолцоо задарч тодорхой бодлого, зохицуулалтгүй болсны улмаас олон тулгамдсан асуудал бий болсон юм. Тухайлбал, мэргэжлийн боловсон хүчний хомстолтой холбоотойгоор сүүлийн жилүүдэд зөвхөн ашиг олох зорилго бүхий мэргэжлийн бус хүмүүс нийтийн эзэмшлийн зам талбайд болон стандартын шаардлага хангаагүй, зориулалтын бус байранд зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ эрхлэх хандлага ихсэн, оршин суугч, иргэдийн тав тух, аюулгүй байдлыг алдагдуулж, хүнсний аюулгүй байдалд эрсдэл үүсгэж байна.

Худалдааны харилцааг зохицуулсан хуулийн төсөл 1996 онд боловсруулагдаж, Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан боловч өнөөг хүртэл батлагдаагүй байна. Иймээс худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбар нь Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Зөрчлийн тухай зэрэг 57 хуулийн 100 гаруй зүйл, заалтаар хэсэгчлэн зохицуулагдаж, Төрөөс баримтлах нэгдсэн бодлого дутагдалтай байна.

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэглээ, соёлын хөгжлийг даган худалдаа, үйлчилгээний салбарт шинээр нэвтэрч буй үйлчилгээ, дэвшилтэт техник технологийг дэмжсэн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалт, журам, стандартыг нийцүүлэн шинэчлэх, сайжруулах шаардлагатай байна.

Иймд худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын талаар төрөөс баримтлах бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд "**Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ-2020**" нийслэлийн дэд хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Дэд хөтөлбөрийн зорилго:

Дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлсэн, соёлтой, хүртээмжтэй, чанартай худалдаа, үйлчилгээг хөгжүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

2.2.1. Нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн орчинг сайжруулах.

2.2.2. Нийслэл хотод бизнесийн таатай орчинг бүрдүүлэх.

2.2.3. Салбарын хүний нөөцийн чадавхийг тасралтгүй дээшлүүлэх.

2.2.4. Салбарт шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацийн орчин үеийн ололтыг нэвтрүүлж, хөгжлийг олон улсын жишигт хүргэх нөхцөлийг бүрдүүлэх.

2.2.5. Хэрэглэгчдийн хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, эрүүл, зөв зохистой хэрэглээний дадлыг төлөвшүүлэх.

Гурав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

Дэд хөтөлбөрийг 2018-2020 онд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

<u>3.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд:</u>

3.1.1. Худалдааны тухай хуулийн төсөлд худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн саналыг нэгтгэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.1.2. “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”, “Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барина.

3.1.3. “Худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021:2007”, "Худалдааны газрын ангилал, нэр томьёо MNS6506:2015", "Худалдааны агуулах, Ерөнхий шаардлага MNS5364:2011", “Хоолны газрын ангилал зэрэглэл, үндсэн шаардлага” MNS4946:2005 стандартыг шинэчлэн боловсруулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3.1.4. "Үндэсний ая тухтай сүлжээ дэлгүүр", "Худалдааны автомат, түүнд тавигдах шаардлага"-ын стандартыг шинээр боловсруулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

<u>3.2.Хоёрдугаар зорилтын хүрээнд:</u>

3.2.1. Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, Нийслэлийн хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан мах махан бүтээгдэхүүнээр хангах зорилгоор “Логистикийн сүлжээ”-г хөгжүүлэхэд шаардлагатай тооцоолол хийж, оновчтой шийдлийн зураглал, зөвлөмж боловсруулна.

3.2.2. Худалдаа хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжлийн холбоод, бизнес төвөөр бойжуулах, гарааны бизнесийг дэмжих сургалт, зөвлөгөөг үзүүлж, мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.

3.2.3. 5S, Кайзен, ISO:9001, үйлчилгээний чанарын индексийг нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгжид олон улсын жишиг "Үйлчилгээний төгөлдөршил" /Service excellence/ шагналыг олгоно.

3.2.4. "Төр-Төрийн бус байгууллага-Хувийн хэвшил"-ийн хамтын ажиллагааг сайжруулж, бизнес эрхлэгчдийн таатай орчинг бүрдүүлнэ.

3.2.5. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг олон улсын форум, сургалт, семинар, үзэсгэлэн худалдаанд оролцуулна.

3.2.6. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хялбаршуулсан гарын авлага, зөвлөмж, зааварчилгаа боловсруулж вэб сайтад байршуулна.

3.3.Гуравдугаар зорилтын хүрээнд:
3.3.1. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна.

3.3.2. Салбарын ажиллагсдын мэргэжлийн зэрэглэл, ур чадварын түвшинг тогтоох ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.3.3. Үндэсний болон Олон улсын ур чадварын тэмцээнд тогооч, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг оролцуулна.

3.4.Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:
3.4.1. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээнд дэвшилтэт технологи, инновацийг франчайз хэлбэрээр нутагшуулж, Үндэсний сүлжээг хөгжүүлнэ.

3.4.2. Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлнэ.

3.4.3. Хүнсний бүтээгдэхүүний хаяг, шошго, хоолны цэсэд шим тэжээлийн мэдээллийг тусгана.

3.4.4. Худалдаа, үйлчилгээний байгууллагуудад хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.4.5. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад зохистой дадал нэвтрүүлнэ.

3.4.6. "Ногоон хөгжил"-ийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж, "Ногоон худалдан авалт"-г нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт нэвтрүүлнэ.

3.5.Тавдугаар зорилтын хүрээнд:
3.5.1. Хүүхдийн хоолны стандарт жор технологийг боловсруулна.

3.5.2. Хоол хүнсний эрүүл, зөв зохистой хэрэглээний дадлыг төлөвшүүлэх, Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэглэгчдэд зориулсан шинжлэх ухааны үндэслэлтэй цуврал нэвтрүүлэг бэлтгэж сурталчлана.

3.5.3. "Эрүүл Залуус" аяны хүрээнд: Оюутнуудын дунд "Өглөөний хоол" төсөл, ЕБС-ийн сурагчдад "Өөг өглөө" төслийг хэрэгжүүлнэ.

3.5.4. Нийслэлийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт "Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги"-ийг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Дэд хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

Үр нөлөө: Нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн орчин сайжирч, бизнес эрхлэх таатай орчин бүрдэн, хүний нөөцийг чадавхижуулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлснээр хэрэглэгчдийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанар, соёл дээшилнэ.

Бүтээгдэхүүн:

1. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн орчин сайжирна.
2. Тээвэр, логистикийн оновчтой шийдлийн загвар бий болно.
3. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн гарааны бизнесийг дэмжиж, шинэ дэвшилтэт техник технологи, инновацийг нэвтрүүлж, ажлын байр нэмэгдэнэ.
4. Олон улсын жишиг "Үйлчилгээний төгөлдөршил" /Service excellence/ шагнал олгоно. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг хийнэ.
5. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, тав тухыг хангасан орчныг бүрдүүлж, сэтгэл ханамжийг дээшлүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, соёл дээшилнэ.
6. "Төр-Төрийн бус байгууллага-Хувийн хэвшил"-ийн хамтын ажиллагааг сайжруулж, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлнэ.
7. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээнд дэвшилтэт технологи, инновацийг франчайз хэлбэрээр нутагшуулж, олон улсын жишигт нийцсэн "Үндэсний сүлжээ"-г хөгжүүлнэ.
8. "Ногоон худалдан авалт"-ыг нийслэлийн худалдаа, үйлчилгээний салбарт нэвтрүүлнэ.
9. Хүүхдийн хоолны стандарт жор технологи боловсруулж, нэвтрүүлнэ.
10. Хүн амын хоол хүнсний зохистой хэрэглээний мэдлэг боловсрол дээшилж, хандлага, дадал төлөвшин, хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Шалгуур үзүүлэлт:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2017 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хэрэгжилтийн явц болон үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	
				Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
1.	Нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн орчинг сайжруулах	Шинэчилсэн журам	тоо	-	2020	2
		Шинэчилсэн стандарт	тоо	-	2020	4
		Шинээр боловсруулсан стандарт	тоо	-	2020	2
2	Нийслэл хотод бизнесийн таатай орчинг бүрдүүлэх.	Худалдааны салбарт тээвэр, логистикийг шийдэх оновчтой шийдлийн загвар	тоо	-	2020	1
		Мэргэжлийн холбоод, Бизнес төвөөр сургалт, зөвлөгөөг үзүүлж, мэдээ мэдээллээр хангах	тоо	30	2020	600
		5S, Кайзен, ISO-9001, үйлчилгээний чанарын	тоо	-	2020	6

		индексийг нэвтрүүлсэн, олон улсын жишиг "Үйлчилгээний төгөлдөршил" шагналтай ААН				
		Сургалт /Тэмцээн уралдаан	тоо	5	2020	36/6 удаа
		Олон улсын форум, үзэсгэлэн, семинарт оролцсон ААН, БЭ	тоо	40	2020	200
		Эрх зүйн баримт бичиг, хялбаршуулсан гарын авлага, зөвлөмж зааварчилгаа	тоо	-	2020	8
3	Салбарын хүний нөөцийн чадавхийг тасралтгүй дээшлүүлэх.	Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн ажилтан	тоо	-	2020	300
		Үндэсний болон олон улсын тэмцээн	тоо	-	2020	10
		Зохистой дадлын зөвлөмж	тоо	-	2020	1
4	Салбарт шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацийн орчин үеийн ололтыг нэвтрүүлж, хөгжлийг олон улсын жишигт хүргэх нөхцөлийг бүрдүүлэх.	Ая тухтай сүлжээ дэлгүүр/ Үндэсний сүлжээ хоолны газар	тоо	5/6	2020	10/12
		Аялал жуулчлалын хоол үйлдвэрлэл үйлчилгээний брэнд бүтээгдэхүүн "UB naadam" "UB green food" "UB MICE food" "UB event food"	тоо	-	2020	4
		Хүнсний бараа бүтээгдэхүүний хаяг шошго, хоолны цэсэнд илчлэг тодорхойлогдсон	хувь	-	2020	100
		Хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээ	тоо	25	2020	750
		Ногоон худалдан авалтыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж	хувь	2	2020	20-30
5	Хэрэглэгчийн хэрэглээний мэдлэг боловсролыг дээшлүүлэх.	Хүүхдийн хоолны стандарт жор технологи	тоо	-	2020	88
		"Өглөөний хоол", "Өег өглөө" төсөлд хамрагдсан оюутан, сурагч	тоо	-	2020	5000
		Хэрэглэгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх цуврал нэвтрүүлэг	Тоо/ давтал т	-	2020	36/72
		Давсны хэрэглээг бууруулсан хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар	Хувь	-	2020	30

Тав. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улс, нийслэл, дүүргийн орон нутгийн төсөв
- Гадаад, дотоодын зээл тусламж, төсөл хөтөлбөр
- Бусад

Зургаа. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

6.1 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлнэ.

6.2 Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан, хоёр жил тутам Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

6.3 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

---oOo---

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 24 өдөр Дугаар А/480 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, 29.1.6-гийн “а”, 29.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 15/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ-2020” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ С.БАТБОЛД

111020002211

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
05 дугаар сарын 24-ны өдрийн
А/480 дугаар захирамжийн хавсралт

“ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ-2020” НИЙСЛЭЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Дэвшилтэт технологи, инноваци нэвтэрсэн соёлтой, хүртээмжтэй, чанартай худалдаа үйлчилгээг хөгжүүлнэ.				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрх зүйн орчин сайжирч, бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, хүний нөөцийг чадавхжуулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлснээр хэрэглэгчдийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанар соёл дээшилнэ.				
Үйл ажиллагааны чиглэл		“ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ-2020” НИЙСЛЭЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨР				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Зорилт 1. Нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн орчинг сайжруулна.						
1.1	Нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын эрх зүйн орчинг сайжруулна.	1. Худалдааны тухай хуулийн төсөлд худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн саналыг нэгтгэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	-Аж ахуйн нэгж, бизнесийн эрхлэгчдийн санал -Цахим худалдааны журам, худалдааны франчайзингийг журамлах санал хүргүүлсэн байна.	УБЗАА	ХХААХҮЯ, ДЗДТГ, МҮХАҮТ, ИДС, ТББ ААН, БЭ	2018-2020
		2. Журам шинэчлэн боловсруулах: • “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”-ыг шинэчлэн боловсруулж НИТХ-д өргөн барина. • “Нийслэлийн нутаг дэвсгэрт соргуулуулах үндаа худалдах түүгээр үйлчлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж НИТХ-д өргөн барина.	2 журам батлагдсан байна.	УБЗАА	ДЗДТГ, ААН, БЭ	2018

		3. Стандарт шинэчлэн боловсруулах: • "Худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS5021:2007", • "Худалдааны газрын ангилал, нэр томьёо MNS6506:2015", • "Худалдааны агуулах, Ерөнхий шаардлага MNS5364:2011" стандарт, • "Хоолны газрын ангилал зэрэглэл үндсэн шаардлага" MNS4946:2005,	4 стандарт батлагдсан байна.	УБЗАА	ХХААХҮЯ, СХЗГ, НМХГ, ДЗДТГ, МҮХАҮТ, ЭШБ ТББ	2018-2020
		4.Стандарт шинээр боловсруулах: • "Үндэсний ая тухтай сүлжээ дэлгүүр" стандарт • "Худалдааны автомат, түүнд тавигдах шаардлага"-ын стандарт	2 стандарт батлагдсан байна.			2018-2020
Зорилт 2. Нийслэл хотод бизнесийн таатай орчинг бүрдүүлнэ.						
2.1	Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, бараа татан авалт, тээвэрлэлтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Логистик сүлжээ"-г хөгжүүлэхэд шаардлагатай тооцоолол хийнэ.	1. Нийслэлийн худалдааны газруудын логистик, нийлүүлэлтийн сүлжээний нөхцөл байдлыг судалж, үр ашгийг нэмэгдүүлэх тооцоолол хийж, оновчтой шийдлийг илэрхийлсэн зураглал, зөвлөмж боловсруулна.	Нийслэлийн хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан мах махан бүтээгдэхүүнээр хангах зорилгоор тээвэр, логистикийн оновчтой шийдэл гарсан байна.	УБЗАА	ХХААХҮЯ, НХХААГ, ДЗДТГ, ТББ ААН	2018-2020
2.2	Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлнэ.	1. Худалдаа хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжлийн холбоод, бизнес төвөөр бойжуулах, гарааны бизнесийг дэмжих сургалт, зөвлөгөөг үзүүлж, мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан байна.	600 бизнес эрхлэгч ба иргэд сургалт, зөвлөгөөг авч гарааны бизнес болон шинэ дэвшилтэт техник технологи нэвтэрсэн байна.	УБЗАА	ДЗДТГ, МҮХАҮТ, БИТ ТББ, БЭЭТ	2018-2020
		2. 5S, Кайзен, ISO:9001, Үйлчилгээний чанарын индексийг нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж шалгарсан аж ахуйн нэгжид олон улсын жишиг "Үйлчилгээний төгөлдөршил" /Service excellence/ шагнал бий болгоно.	Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг GAP & SERVQUAL загвараар хийх. Жил бүр 2 хүртэл аж ахуйн нэгжийг урамшуулсан байна.	УБЗАА	ДЗДТГ, МҮХАҮТ, МБТ, ИДС, МХ, ТББ, ААН	2018-2019

		3. "Төр-Төрийн бус байгууллага-Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, бизнес эрхлэгчдийн таатай орчинг бүрдүүлнэ.	Сургалт- 36 , Зөвлөх үйлчилгээ-12, "Business Festival", "Business League" гэх мэт тэмцээн уралдаан- 6 удаа зохион байгуулсан байна.	УБЗАА	НХГ, ДЗДТГ, МҮХАҮТ, МХ, ТББ ААН, БЭ	2018-2020
		4. Олон улсын форум, сургалт семинар, үзэсгэлэн худалдаанд оролцуулна.	Жилд 200-аас доошгүй худалдаа үйлчилгээний салбарын ажиллагсад хамрагдсан байна.	УБЗАА	ХХААХҮЯ, МҮХАҮТ, ДБ ТББ, ААН	2018-2020
		5. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан хялбаршуулсан гарын авлага, зөвлөмж зааварчилгаа боловсруулж вэб сайтад байршуулна.	6 гарын авлага, 2 зөвлөмж зааварчилгаа боловсруулж, вэб сайтад байршуулсан байна.	УБЗАА	НМТГ, ДЗДТГ МҮХАҮТ, ИДС, ТББ, ААН, БЭ	2018-2020
Зорилт 3. Салбарын хүний нөөцийн чадавхийг тасралтгүй дээшлүүлнэ.						
3.1	Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, салбарт ажиллагсдын мэргэжил, ур чадварын түвшинг тогтооно.	1. Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна. 2. Салбарын ажиллагсдын мэргэжлийн зэрэглэл, ур чадварын түвшинг тогтоох ажлыг үе шаттай зохион байгуулна.	Салбарын ажилчдын мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна.	УБЗАА	НХЭГ, ДЗДТГ, МҮХАҮТ, МХ, ТББ, ИДС, ААН	2018-2020
		3. Үндэсний болон Олон улсын ур чадварын тэмцээнд тогооч, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг оролцуулна.	Жилд 2-оос доошгүй тэмцээнд оролцуулж, олон улсын түвшинд хүрсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэсэн байна.	УБЗАА	ДЗДТГ, НХЭГ, МҮХАҮТ, ТББ ИДС, ААН	2018-2020
Зорилт 4. Салбарт шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацийн орчин үеийн ололтыг нэвтрүүлж, хөгжлийг олон улсын жишигт хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.						
4.1	Худалдаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дэвшилтэт технологи иноваци нэвтрүүлж үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлнэ.	1. Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээнд инновацийг франчайз хэлбэрээр нутагшуулсан "Үндэсний сүлжээ" -г хөгжүүлнэ.	• Ая тухтай сүлжээ дэлгүүр, • Үндэсний сүлжээ хоолны газар	УБЗАА	ХХААХҮЯ, НХЭГ, ДЗДТГ, ТББ, ААН	2019-2020
		2. Аялал жуулчлалын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлнэ.	Брэнд үйлчилгээ "UB naadam" "UB green food" "UB MICE food" "UB event food" загварууд бий болсон байна.	УБЗАА	АЖГ, ДЗДТГ, МҮХАҮТ, ТББ ЭШБ, ААН	2018-2020

		3. Хүнсний бараа бүтээгдэхүүний хаяг шошго, хоолны цэсэнд шим тэжээлийн мэдээллийг тусгана.	Хүнсний бараа бүтээгдэхүүний хаяг шошго, хоолны цэсэнд илчлэг 100% тодорхойлогдсон байна.	УБЗАА	НЭМГ, НМХГ, ДЗДТГ, ААН	2018-2020
		4. Худалдаа, үйлчилгээний байгууллагуудад хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Худалдаа, үйлчилгээний 750 газарт хүүхэд саатуулах амрах орчин, хүүхдийн хоолны цэсийг нэвтрүүлсэн байна.	УБЗАА	НХГБХДГ, НМХГ, ДЗДТГ, ААН, БЭ	2018-2020
		5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад зохистой дадал нэвтрүүлнэ.	Зохистой дадлын зөвлөмж боловсруулагдсан байна.	УБЗАА	ХХААХҮЯ, НМХГ, ДЗДТГ ТББ, ААН	2018-2020
4.2	"Ногоон хөгжил"-ийн үзэл баримтлалыг хэрэгжүүлж, "Ногоон худалдан авалт"-г нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт нэвтрүүлнэ.	1. Ногоон хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, "Утаагүй Улаанбаатар" ажлын хүрээнд: • Худалдаа үйлчилгээний газарт эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур ашиглахыг дэмжиж агаарын бохирдлыг бууруулна. • Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Нийслэлийн гэр хорооллын худалдаа үйлчилгээний цэг салбарын 30-аас доошгүй хувийг эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуурт шилжүүлснээр агаарын бохирдол тодорхой хэмжээгээр буурсан байна. Нийслэлийн хэмжээнд хог ангилан ялгах нөхцөл бүрдсэн байна.	УБЗАА	АББГ, "УБХК" ХК, НГХДБГ, ДЗДТГ, ААН, БЭ	2018-2020
		2. Худалдаа үйлчилгээний газрууд нь органик бүтээгдэхүүний хаяг шошго бүхий бараа бүтээгдэхүүнийг тусгайлсан тасагт байршуулсан байна.	Нийт худалдаа үйлчилгээний газрын 20 хүртэл хувьд тусгайлсан тасаг бий болсон байна.	УБЗАА	ДЗДТГ, МҮХАҮТ, ААН, ТББ	2018-2020
Зорилт 5. Хэрэглэгчдийн хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, эрүүл, зөв зохистой хэрэглээний дадлыг төлөвшүүлнэ.						
5.1	Хэрэглэгчийн хоол хүнсээ сонгох, хэрэглэх хандлагыг өөрчлөн эрүүл зөв зохистой дадлыг төлөвшүүлнэ.	1. Хүүхдийн хоолны стандарт жор технологи боловсруулна.	Хүүхдийн хоолны 88 төрлийн стандарт жор технологи боловсруулсан байна.	УБЗАА	НБГ, НӨХГ ИДС, ТББ, ЕБС, СӨБ	2018-2020
		2. Хоол хүнсний эрүүл, зөв зохистой хэрэглээний дадлыг төлөвшүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор олон нийтийн мэдээллийн нэгдсэн сүлжээ телевиз, радиогоор шинжлэх ухааны үндэслэлтэй цуврал нэвтрүүлэг гаргана.	Хүн амд эрүүл зохистой хэрэглээ, дадал төлөвшсөн байна.	УБЗАА	ДЗДТГ, МҮХАҮТ, ИДС, ТББ, ААН	2018-2020

		3. “Эрүүл Залуус” аяны хүрээнд: • Оюутнуудын дунд “Өглөөний хоол” төсөл • ЕБС-ийн сурагчдад “Өег өглөө” төслийг хэрэгжүүлнэ.	Төсөлд оюутан, сурагчид хамрагдсан байна.	УБЗАА	НИТХ, НБГ МОХ, ИДС, ЕБС ОУТБ, ААН, БЭ	2018-2020
		4. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт “Давсны хэрэглээг бууруулах” үндэсний стратегийг хэрэгжүүлнэ.	Нийт хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрын 30 хувьд давсны хэрэглээг бууруулсан байна.	УБЗАА	ХХААХҮЯ, НЭМХ, ДЗДТГ, ТББ, ААН	2018-2020

Товчилсон үг:

- ХХААХҮЯ- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- СХЗҮГ-Стандартчилал хэмжил зүйн үндэсний газар
- МХЕГ- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- ШӨХТГ-Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
- НЭМХ-Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн
- НЗДТГ –Нийслэлийн Засаг даргын тамгын газар
- УБЗАА- Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
- НХТЕТГ-Нийслэлийн хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газар
- НӨХГ -Нийслэлийн өмчийн харилцааны газар
- НАЖГ-Нийслэлийн аялал жуулчлалын газар
- НМХГ-Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
- НБГ –Нийслэлийн боловсролын газар
- НМТГ-Нийслэлийн мэдээлэл технологийн газар
- НХЭГ -Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар
- НҮИГ-Нийслэлийн үйлдвэрлэл иновацийн газар
- НХГБХДГ-нийслэлийн гэр бүл хөгжлийг дэмжих газар
- АББГ-Агаарын бохирдлыг бууруулах газар

- НГХДБГ-Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар
- НГА-Нийслэлийн газрын алба
- "УБХК" ХК-Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК
- ДЗДТГ –Дүүргийн Засаг даргын тамгын газар
- ЭШБ – Эрдэм шинжилгээний байгууллага
- МҮХАҮТ –Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
- Дэлхийн банк
- ИДС -Их дээд сургууль
- ОУТБ -Олон улсын төслийн байгууллага
- МБТ-Монголын бүтээмжийн төв
- МОХ – Монголын оюутны холбоо
- ТББ –Төрийн бус байгууллага
- МХ- Мэргэжлийн холбоод
- БЭЭТ-Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төв
- ААН-Аж ахуйн нэгж
- БЭ – Бизнес эрхлэгчид